

МОНГОЛ, ЯПОНЫ ДИПЛОМАТ ХАРИЛЦААНЫ  
45 ЖИЛИЙН ОЙН НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНД ХЭЛЭХ ҮГ

Эрхэмсэг ноён Элчин сайд Масато Такаока,  
Эрхэм хүндэт зочид оо,  
Хатагтай ноёд оо,

Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойн нээлтийн ёслолын арга хэмжээнд бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Монгол, Япон хоёр улс 45 жилийн тэртээ дипломат харилцаа тогтоосноос хойш бидний харилцаа тасралтгүй урагшилж, эдүгээ хоёр ард түмний нийтлэг эрх ашиг, нэгдмэл үнэт зүйлс, харилцан итгэлцэлд суурилан Стратегийн түншлэлийн түвшинд амжилттай хөгжиж байна. Энэхүү эрхэм харилцааг хөгжүүлэхийн төлөө чин сэтгэлээсээ зүтгэж, харилцааны түүхийг бүтээлцэж ирсэн төр, нийгмийн зүтгэлтнүүд, ахмад дипломатчиддаа мэхийн ёслоё.

Дипломат харилцаа тогтоосноос хойш хэвийн, тогтвортой урагшилж ирсэн Монгол, Японы харилцаа манай улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990-ээд оноос эрчимтэй хөгжиж эхлэв. Япон Улсын Ерөнхий сайд Т.Кайфу Монгол орны шинэчлэлийг дэмжигчдийг түүчээлэн 1991 онд манай улсад албан ёсоор айлчилж, Япон Улсын Засгийн газар Монголд хандивлагчдын уулзалтыг Дэлхийн банктэй хамтран Токио хотноо 10 удаа зохион байгуулсан нь түүхийн хуудаснаа тодрон үлджээ. Та бүхний дэмжлэг тусламж Монгол орны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсаар байгаад бид гүнээ талархахын хамт жаргаж зовохын цагт бие биеэ дэмжин, тулж түшдэг анд нөхөд байхыг ямагт эрмэлзэж ирсэн.

Монгол, Японы харилцаа 1997 оноос Иж бүрэн түншлэлийн, 2010 оноос Стратегийн түншлэлийн түвшинд хөгжиж байна. Харилцан айлчлалын давтамж өсч, хамтын ажиллагааны эрх зүйн үндэс бэхжиж, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр байгуулагдав. Бид цаашид харилцааны ололт амжилтаа улам зузаатгаж, бүс нутагтаа бие биенээ орлуулшгүй чухал түнш улс орнууд байх болно.

Монгол Улсын Засгийн газраас дипломат харилцааны 45 жилийн ойг Зохион байгуулах Хороог томилон ажиллуулж байна. Бид саяхан Хорооныхоо анхны хурлыг зохион байгуулж, энэ онд Монгол, Японы харилцааг сурталчлан таниулахад чиглэсэн 45 арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлээд байна.

Эдгээр ажлуудыг манай олон нийт идэвхтэй дэмжиж, Зохион байгуулах Хороотой нягт хамтран ажиллаж байгааг тэмдэглэхэд нэн таатай байна.

Монгол, Японы харилцааг хөгжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулж буй Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн ялдамд ойн баярын үйл ажиллагаа, гэрэл зургийн үзэсгэлэнг албан ёсоор нээснийг мэдэгдэе.

Энэхүү хундагыг Монгол, Японы ард түмний найрамдал нөхөрлөл, манай хоёр орны Стратегийн түншлэлийн төлөө, энд хүрэлцэн ирсэн Та бүхний эрүүл мэнд, сайн сайхны төлөө өргөө.